

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ  
эрдэм шинжилгээний бичиг

Tom. XXXIII (359)

2011

134-136

ХЭН, ЯМАР СЭДВЭЭР, ХААНА, ХЭЗЭЭ...

Ю.Мөнх-Амгалан\*

Хэл шинжлэлийн чиглэлээр гадаад, дотоодод эрдмийн зэрэг хамгаалсан судлаачдын бүтээлийн тухай товч мэдээллийг эмхэтгэн хэвлэдэг өмнөх туршлагыг<sup>1</sup> үргэлжлүүлэн энэ удаа товч боловч дараах зүйлийг нийтэлж байна.

Монгол Улсын БСШУ-ны сайдын 2010 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийн тухай 492 тоот тушаалыг үндэслэн мөн сайдын 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 28 тоот тушаалаар тус улсад докторын зэрэг хамгаалуулах эрх бүхий 27 зөвлөлийг эмхлэн байгуулсны дотор хэлбичиг, утга зохиолын докторын зэрэг хамгаалуулах зөвлөл орсон бөгөөд тус зөвлөл одоо дурдсан чиглэлээр докторын зэрэг хамгаалуулах ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Энэ удаа 2010 онд хэл шинжлэл, төрөл бус хэлний зэрэгцүүлсэн хэл шинжлэлийн чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөл болон БСШУ-ны сайдын 2010 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 492 дугаар тушаалаар зохион байгуулагдсан докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хэл шинжлэлийн асуудлаар

\* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

<sup>1</sup> Ц.Өнөрбаян, Б.Пүрэв-Очир Хэн, ямар сэдвээр, хэзээ, хаана? -Ц.Өнөрбаян, Б.Пүрэв-Очир Монгол хэлний судлалын онол-практикийн зарим асуудал. I. Уб., 1991. 118-125 дахь тал; Б. Пүрэв-Очир, З. Гулираанз Хэн, хэзээ, хаана, ямар сэдвээр... -Б.Пүрэв-Очир, З.Гулираанз Монгол хэлний өгүүлбэрзүйн онол-практикийн зарим асуудал. II. Уб., 1993. 86-87 дахь тал; Б.Пүрэв-Очир, Ю.Мөнх-Амгалан, З. Гулираанз Хэн, хэзээ, хаана, ямар сэдвээр. -Б.Пүрэв-Очир, Ю.Мөнх-Амгалан, З.Гулираанз Монгол хэлний энгийн өгүүлбэр, эхийн онол-практикийн зарим асуудал. III. Уб., 1995. 151 дэх тал; Ю.Мөнх-Амгалан Хэн, хэзээ, хаана, ямар сэдвээр... - “Эрдэм шинжилгээний бичиг”. МУИС. МСДС. 1997. № 10 (122).185-186 дахь тал; Ю.Мөнх-Амгалан Хэн, ямар сэдвээр, хаана, хэзээ... - “Монголын судлалын эрдэм шинжилгээний бичиг”. МУИС. МСС. 1999. № 15 (153). 281-282 дахь тал; Ю.Мөнх-Амгалан Хэн, ямар сэдвээр, хэзээ... - “Монголын судлалын эрдэм шинжилгээний бичиг”. МУИС. МХСС. 2003. № 21 (220). 187-190 дэх тал; Ю. Мөнх-Амгалан Хэн, ямар сэдвээр, хаана, хэзээ...- “Монгол судлал”. МУИС. МХСС. 2004. Боть ХХII (328). 271-277 дахь тал; Б.Пүрэв-Очир, Ю.Мөнх-Амгалан, Ц.Өнөрбаян, З.Гулираанз Хэн, ямар сэдвээр, хэзээ, хаана? (Хэлшинжлэлийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэд). - “Эрдэм шинжилгээний бичиг”. Гадаад хэлний сургууль. МУБИС. 2006. 157-174 дэх тал; Ю.Мөнх-Амгалан Хэн, ямар сэдвээр, хаана, хэзээ...- “Монгол судлал”. Эрдэм шинжилгээний бичиг. МУИС. МХСС. 2007. No. 27 (285). 304-307 дахь тал; Б.Пүрэв-Очир, Ю.Мөнх-Амгалан, Ц.Өнөрбаян, З.Гулираанз Хэн, ямар сэдвээр, хэзээ, хаана? (Хэлшинжлэлийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэд). - “Монгол судлалын чуулган”. МСС. МУБИС. 2007. VII боть. № 1 (37). 243-256 дахь тал; Ю.Мөнх-Амгалан Хэн, ямар сэдвээр, хаана, хэзээ... - “Монгол судлал”. Эрдэм шинжилгээний бичиг. МУИС. МХСС. 2010. Боть ХХХI (328). 227-235 дахь тал.

эрдмийн зэрэг хамгаалсан хүмүүсийн бүтээлийн сэдэв, холбогдох мэдээллийг хамгаалалт болсон сар, өдрөөр нь дараалуулан товч хэрэглэгдэхүүн болгон толилуулж байна.

Тэрчлэн гадаад оронд эрдмийн зэрэг хамгаалсан зарим хүний бүтээлийг олдохын хэрээр энд нөхөн оруулсан болно. Үүнд:

**Л.Дорждэрэм.** О.М.Ковалевскийн монгол-орос-франц толь бичгийн судалгаа.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Э.Равдан. Уб., 2010. 02.22.

**Э.Мөнх-Учрал.** Хөрвүүлэх программд зориулсан монгол хэлний судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ш.Чоймаа. Уб., 2010.05.28.

**Б.Төмөрхуяг.** Улс төрийн дискурс дэх метафорыг когнитив хэлшинжлэлийн үүднээс судалсан нь (Монгол, орос, англи хэлний жишээн дээр). Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ц.Цэен-Ойдов. Уб., 2010.06.03.

**Ц.Сувд.** Хорьдугаар зууны монгол хүний нэрийн давтамжийн судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ж.Сэржээ. Уб., 2010.06.21.

**Д.Нармандах.** Монгол, англи хэлэнд талархал илэрхийлэх нь. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ч.Зэгиймаа. Уб., 2010.06.30.

**У.Сувданцэцэг.** Монгол улсад англи хэлийг түгээн дэлгэрүүлэх бодлого, түүнийг хэрэгжүүлэх нь /дээд боловсролтой хүмүүст зориулсан эрчимжүүлсэн сургалтын жишээн дээр/. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ч.Зэгиймаа. Уб., 2010.06.30.

**Л.Туул.** Англи хэлний утга шилжсэн үг хэллэгийг монгол хэлнээ буулгах нь. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч А.Шархүү, Т.Төрбат. Уб., 2010.07.14.

**Д.Батжаргал.** Вербаль харилцааг системийн хандлагын үүднээс хэлэхүйн үйлдэл дээр судлах нь. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Т.Төрбат. Уб., 2010. 07.30.

**Л.Ганчимэг.** Монгол хэлний хэлц нэгжийн бүтэц-утгазүйн тогтолцоо. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ж.Баянсан. Уб., 2010.10.15.

**Г.Бямбацэрэн.** Монгол хэлний тодосгогч нэгжүүдийн бүтэц, утга, үүрэг, хэрэглээ. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Б.Пүрэв-Очир. Уб., 2011.04.06.

**С.Алтанцэцэг.** Буриад ардын дууны хэл - соёлын судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ж.Баянсан. Уб., 2011.04.06.

**С.Ганцэцэг.** Монгол оньсогын ангилал, туурвилзүйн онцлог. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ж.Батбаатар. Уб., 2011.04.26.

**Сунг Бёнг Гү.** (송병구, Song Byeong Gu). Орчин цагийн монгол хэлний туслах үйл үгийн судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ц.Шагдарсүрэн. Уб., 2011.04.26.

**Д.Туяа.** Дархадын салбар аман аялгууны онцлог. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ж.Санжаа, Л.Хүрэлбаатар. Уб., 2011.06.08.

**Э.Сонинтогос.** Телевизийн зар сурталчилгааны хэлний онцлог. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ж.Баянсан. Уб., 2011.06.08.

**А.Дэлгэрмаа.** Япон-монгол хэлний хэлцийг орчуулах арга, зарчмын судалгаа (зарим орчуулгын жишээн дээр). Эрдэм шинжилгээний ажлын удирдагч С.Эрдэнэмаам, Ишида Приссилла. Уб., 2011.06.22.

**Д.Будсүрэн.** Цогт хун тайжид холбогдох түүхэн баримтуудын эх бичгийн судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ш.Чоймаа. Уб., 2011.06.22.

**М.Баярсайхан.** Саган сэцэний “Эрдэний Товч”-ийн эх бичиг, үгийн сангийн судалгаа. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ш.Чоймаа. Уб., 2011.06.24.

**Д.Даваасүрэн.** “*Үгийг тодруулагч толь*” тайлбар зохиолын утга зүйн судалгаа. /Цорж Агваандамбын “*Бодьсадвын явдалд орохуйн зүүлт үгийг тодруулагч толь*” тайлбар зохиолын “*Бодь сэтгэлийн тус эрдмийг номлохуй*” нэгдүгээр бүлгийн жишээн дээр/. Эрдэм шинжилгээний ажлын удирдагч Ц. Пүрэвсүрэн, Т. Булган. Уб., 2011.06.24.

\*\*\*

**Верба, Н.К.** Древнемонгольский комплекс с интервокальным согласным и его эквиваленты в современных монгольских языках. АКД. М., 1978.

**Амаржаргал Б.** Лексико-семантические особенности халхаского диалекта. АКД. Улан-Уде., 1994.

**Tóth Erzsébet.** Mongol-Tibeti Nyelvi K'ics'nhatasok. Doktori (PHD) Disszertáció. Budapest., 2008. 222 oldal.